



АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

АУДИТОР

Ажлын хүрээлэл: Компанийн санхүүгийн баримт бичиг, нягтлан бодох бүртгэлийн тайланд тавигдах гадаад болон дотоод хяналтыг хэрэгжүүлнэ.

Гадаад аудитор: Түнш компанийн ажлын байранд тэдний санхүүгийн ажил хэрэг, хуулийн хэрэгжүүлэлт, зөвшөөрөлд хяналт тавина. Ажлын байранд хийж гүйцэтгэх үүргүүд:

- ✓ Компанийн санхүүгийн холбогдолтой асуудлаар ажилтнуудтай ярилцлага хийх
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн данс хөтлөлт, санхүүгийн баримт бичгийн үнэн зөв байдалд шалгалт хийх
- ✓ Санхүүгийн тайланд анализ хийх
- ✓ Бизнес ба нягтлан бодох бүртгэлийн системд шалгалт хийн цаашид авч хэрэгжүүлэх бодлогын зөвлөмж өгөх
- ✓ Компанийн санхүүгийн байдалд үнэн зөв, шударга үнэлгээх өгөх
- ✓ Бизнесийн үнэлгээ хийн эд хөрөнгө битүүмжлэх, үйл ажиллагааны эрхийг хасах
- ✓ Бүртгэл тооцооны үйлчилгээний шүүх үйл ажиллагаанд хуульчидтай хамтран ажиллаж

Дотоод аудитор: Компанийн бүртгэл тооцооны системд тавигдах дотоод хяналтыг хэрэгжүүлнэ. Ажлын байранд хийж гүйцэтгэх үүргүүд:

- ✓ Компанийн санхүүгийн хяналтын системийн давуу ба сул талыг үнэлэх
- ✓ Санхүү, бүртгэл тооцооны баримт бичиг нягтлагч бодох бүртгэлийн стандарт, хууль эрх зүйн орчинд нийцсэж буй эсэхэд хяналт, шалгалт хийх
- ✓ Гадаад аудиторт хэрэгцээтэй компанийн санхүүгийн баримт бичгээр хангах
- ✓ Бодлогын шийдвэрт зөвлөгөө өгөх

Ур чадвар

- ✓ Үнэнч, шударга, итгэл даан ажиллах
- ✓ Хичээгүй, ажил үйлсдээ бие сэтгэлээ зориулж чадах
- ✓ Нягт нямбай
- ✓ Бизнес эрхлэх мэдрэмж, ур чадвартай
- ✓ Харилцааны ур чадвартай, задлан шинжилгээ хийх, асуудал шийдвэрлэх чадвартай
- ✓ Зохион байгуулах, тооцоолох чадвартай
- ✓ Баримт бичиг боловсруулах чадвартай
- ✓ Ажлын ачаалал даах
- ✓ Аливааг сурч, мэдэх хүсэл тэмүүлэл, оролдлоготой
- ✓ Авхаалжтай, сэргэлэн

Тавигдах шаардлага

- ✓ Нягтлан бодох бүртгэл, бизнес удирдлага ба бусад холбогдох мэргэжлээр их дээд сургууль төгссөн
- ✓ Нягтлан бодогчийн мэргэжшүүлэх ба ахисан түвшний сертификат, батламж олгох сургалтыг дүүргэсэн
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн программ хангамжийг мэргэжлийн түвшинд ашиглах чадвартай
- ✓ Компьютерийн хэрэглээний програм дээр ажиллах чадвартай
- ✓ Компьютерийн бүртгэл тооцооны системийн мэдлэгтэй бол давуу тал гэж үзнэ

Карьер хөгжил

Мэдээлэл технологийн аудитор, ахлах аудитор, аудит партнер \хувиараа\ ба улсын болон хувийн хэвшлийн байгууллагуудад нягтлан бодогчоор ажиллах боломжтой.